



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2016 оны 10 сарын 12 өдөр

Дугаар 1449

Булган

**Салбар хороог шинэчлэн
байгуулах тухай**

Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 123 дугаар тогтоол, Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 04 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг дарга, Ажил олгогч эздийн холбоо болон Үйлдвэрчний эвлэлийн холбоог төлөөлөн ажилтны эрх, үүрэг хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах аймгийн хэмжээний байгууллагын төлөөлөл бүхий "Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт салбар хороо"-г /орон тооны бус/ аймгийн Засаг даргын дэргэд байгуулсугай.

2. Салбар хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Төрийн байгууллагын төлөөлөл:

Салбар хорооны дарга: - Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд: - Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

- Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

Үйлдвэрчний эвлэлийн байгууллагын төлөөлөл:

- Аймгийн ҮЭХ-ны дарга

- Аймгийн ҮЭХ-ны тэргүүлэгч

- Аймгийн ҮЭХ-ны тэргүүлэгч

Ажил олгогч эздийн холбооны төлөөлөл:

- Аймгийн АОЭХ-ны тэргүүн

- Аймгийн АОЭХ-ны тэргүүлэгч

- Аймгийн АОЭХ-ны тэргүүлэгч

Нарийн бичгийн дарга: - Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

3. Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт салбар хороог сум, орон нутагт байгуулж ажиллах талаар холбогдох байгууллагуудад чиглэл өгч, аймгийн гурван талт хэлэлцээрийн хэрэгжилтийг ханган, үйл ажиллагааны зардлыг жил бүрийн төсөвт тусгаж байхыг салбар хорооны дарга /Засаг даргын орлогч/-т үүрэг болгосугай.

4. Салбар хорооны бүрэлдэхүүнийг шинэчилсэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын 2013 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн А/405 тоот захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ